



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2025.06.18 № 1/991
танай 2025.06.09-ны № 5/3037 -т

Тайлан хүргүүлэх тухай

Тус газраас ирүүлсэн 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 5/3037 тоот албан бичгийн дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн төвлөрлийг сааруулах салбарын бодлогын хүрээнд хийсэн ажлын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 12 хуудастай

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БЯМБАСҮРЭН



УНТЭ-ИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Эрүүл мэндийн яамнаас орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад хэрэгцээтэй байгаа тусламж үйлчилгээг нутагшуулах, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бууруулах зорилгоор дараах “Үндэсний баг”-уудыг байгуулсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08 сарын 30-ны “Үндэсний баг томилох тухай” А/367 дугаар тушаалаар “Зүрхний хэм судлал”-ын багт УНТЭ-ийн Зүрхний төвийн эмч Г.Ананд, А.Ганцэцэг, Б.Тайхар нар, “Ангиографи”-ийн багт Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Энхзориг, Э.Энхболд, Б.Хадбаатар, Зүрхний төвийн эмч Б.Тайхар, Дүрс оношилгооны төвийн Ангиографийн сувилагч А.Молом нар томилогдон ажиллаж байна.


д/д	Багийн нэр	Хийсэн ажлын тайлан
1	Зүрхний хэм судлалын баг	Зүрхний хэм судлалын үндэсний баг Люксембургийн Их Гүнт Улсын дэмжлэгтэй MON007 төслийн санхүүжилтээр 2024 оны 09 сарын 17-ны өдөр нийт 21 аймаг, 6 дүүргийн зүрх судасны эмч нарт “Холтер шинжилгээний талаарх ерөнхий ойлголт, хэм алдагдлыг хэрхэн илрүүлэх, дүгнэх” 1 өдрийн онолын сургалт зохион байгуулсан. Зүрхний төвийн эмч А.Ганцэцэг 25 хүнд үзлэг хийснээс 1 эмчлүүлэгчид аблаци эмчилгээг хийлгүүлэхээр Улаанбаатар хот руу илгээн, 2 үйлчлүүлэгчид холтер шинжилгээг хийж, аппаратыг хэрхэн ажиллуулах, хэрхэн уншиж, дүгнэх талаар ажлын байран дээрх сургалт хийсэн. Мөн БОЭТ-ийн 27 эмчид “Аминд аюултай зүрхний хэм алдагдал”, “Тосгуурын жирвэгнээ” сэдвээр сургалт зохион байгуулсан.    Зураг 1. /УНТЭ/ А.Ганцэцэг эмчийн сургалтын явцаас

2024 оны 10 сарын 01-ний өдрөөс 12 сарын 10-ны өдрийн хугацаанд үндэсний багийн гишүүд болон УНТЭ-ийн эмч нар тосгуурын жирвэгнээ 10, ховдлын хэм алдагдал 3, ховдлын дээрх хэм алдагдал 49, нийт 62 аблаци эмчилгээ хийсэн.

Үүнээс

- Үндэсний баг 16,
- Бүгд Найрамдах Армени Улсын профессор Армен Хачатрянтай хамтран 20,
- Канад Улсын профессор Фахад Алмехмадитай хамтран 19,
- Гүрж Улсын профессор Ройн Рекваватай хамтран 7 ажилбар хийсэн.

2025 оны 04 сарын 01-10-ны өдрүүдэд УНТЭ-ийн Зүрхний төвийн их эмч Г.Ананд Дорнод аймагт үндэсний багийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж, нийт 200 хүнд үзлэг, зүрхний хэт авиа 30, холтер мониторингийн шинжилгээг 4 хүнд хийсэн. Мөн БОЭТ-ийн нийт эмч, мэргэжилтнүүдэд “Аминд аюултай хэм алдагдал” сэдвээр лекц уншсан.



Зураг 2. Г.Ананд /УНТЭ/ эмчийн үзлэг, сургалтын явцаас

2

Ангиографийн
баг

1. 2024 оны 09 дүгээр сард УНТЭ-ийн Дүрс оношилгооны төвийн Ангиографийн сувилагч А.Молом Өмнөговь аймагт “Зүрхний шигдээстэй өвчтөний титэм судсан дотуурх эмчилгээний дараах хяналт, асаргаа, сувилгаа” сэдвээр танхимын сургалт хийн, БОЭТ-ийн эрчимт эмчилгээний тасгийн сувилагч нарыг ажлын байран дээр чадавхжуулсан.
2. 2024 оны 10 сарын 28-аас 11 сарын 06-ны өдрүүдэд УНТЭ-ийн Зүрхний төвийн эмч А.Ганцэцэг, Б.Тайхар, Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Энхзориг нар Өмнөговь аймагт ажиллах үндэсний багийн бүрэлдэхүүнд томилогдон ажилласан. Зүрхний төвийн эмч Б.Тайхар, УГТЭ-ийн Судсан дотуурх оношилгоо, эмчилгээний төвийн эмч Ц.Дамдинсүрэн нар хамтран 216 иргэнд амбулаторийн үзлэг, 89 иргэнд зүрхний эхо шинжилгээ хийж, зөвлөгөө өгсөн. Өмнөговь аймгийн БОЭТ-ийн яаралтай тусламжийн тасгаар ирсэн 10 үйлчлүүлэгчид PCI хийж, 13 тохиолдолд ангиографийн ажилбар хийж, стент тавив.



Зураг 3. Өмнөговь аймагт ажилласан үндэсний багийн бүрэлдэхүүн



Зураг 4. Б.Тайхар эмчийн оношилгоо, эмчилгээний явцаас

Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Энхзориг УГТЭ-ийн Судсан доторх оношилгоо, эмчилгээний төвийн зөвлөх эмч Р.Болдбат нар хамтран 189 иргэнд амбулаторийн үзлэг, 14 үйлчлүүлэгчид эхо шинжилгээ, 2 эмчлүүлэгчид TFCA оношилгоо хийж, зөвлөгөө өгсөн. Өмнөговь аймгийн БОЭТ-ийн Мэдрэлийн тасгийн Г.Шижирээ эмчтэй хамтран үзлэг хийж, зөвлөгөө өгөв.



Зураг 5. Б.Энхзориг эмчийн оношилгоо, эмчилгээний явцаас

3. 2024 оны 10-р сарын 06-10-ны өдрүүдэд УНТЭ-ийн Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Энхзориг Өвөрхангай аймагт Ангиографийн үндэсний багийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж, 1 тохиолдолд тархины судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийсэн.



Зураг 6. Б.Энхзориг эмч /УНТЭ/ Өвөрхангай аймагт 2024 онд

4. 2025 оны 01 сарын 05-11-ний өдрүүдэд УНТЭ-ийн Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Энхзориг Өвөрхангай аймагт Ангиографийн үндэсний багийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж, 2 тохиолдолд тархины судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийсэн. Мөн Өвөрхангай аймгийн БОЭТ-ийн эмч, мэргэжилтнүүдэд ажлын байран дээр дадлагажуулах сургалт хийсэн.



Зураг 7. Б.Энхзориг /УНТЭ/ эмч Өвөрхангай аймаг 2025 онд

5. 2025 оны 03 сард УНТЭ-ийн Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Э.Энхболд Өмнөговь аймагт Ангиографийн үндэсний багийн бүрэлдэхүүнд томилогдон ажилласан.



Зураг 8. Э.Энхболд /УНТЭ/ эмчийн хийсэн мэс заслын явцаас

6. 2025 оны 01 сарын 12-нд УНТЭ-ийн Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Энхзориг Өвөрхангай аймгийн Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн эмч нарт “Харвалтын оношилгоо, эмчилгээ” сэдвээр сургалт хийсэн.



Зураг 9. Сургалтын явцаас

7. 2024 оны 12 сарын 13-24-ний өдрүүдэд Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Хадбаатар Ховд аймагт ажиллах үндэсний багт томилогдон ажилласан. Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Хадбаатар орон нутагт анх удаа “Зүүн нугалмын артерийн нарийсалтад стент тавих мэс засал” хийсэн. Мөн нийт 96 хүнд үзлэг хийн, зөвлөгөө өгч, 14 хүнд тархины судасны ангиографийн оношилгоо, эмчилгээ хийсэн. Түүнчлэн Ховд аймгийн БОЭТ-ийн 15 эмчид “Гүрээний судасны нарийсалтад стент тавих мэс засал, үр дүн” сэдвээр мэдээлэл сургалт зохион байгуулсан.



Зураг 10.

Ховд аймагт хийсэн мэс заслын явцаас



Зураг 11.

Б.Хадбаатар /УНТЭ/ эмчийн сургалтын явцаас

		8. 2025 оны 03 сарын 04-05-ны өдрүүдэд УНТЭ-ийн Мэдрэлийн эмнэлзүйн төвийн эмч Б.Энхзориг Өвөрхангай аймгийн БОЭТ-д томилогдон ажиллаж, Каротид артерид тэлэгч тавих мэс засал хийсэн. 9. 2025 оны 02 сард УНТЭ-ийн Зүрхний төвийн эмч Б.Тайхар Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэгт томилогдон ажиллаж, 90 гаруй амбулаторийн үзлэг хийн, 16 Ангиографийн оношилгоо, эмчилгээ хийсэн.
3	Чих хамар, хоолойн мэс заслын чиглэлээр	1. 2025 оны 02 сарын 17-21-ний өдрүүдэд УНТЭ-ийн ЧХХСМЗТ-ийн эмч Н.Ган-Эрдэнэ Орхон аймгийн БОЭТ-д томилогдон ажиллаж, нийт 15 мэс засал хийсэн. Үүнд чихний хэнгэрэг нөхөх мэс засал 5, хамрын дурангийн мэс засал 8, гадна хамрын хуучин хугарал засах мэс засал 2-ыг хийсэн. Тус хугацаанд орон нутагт анх удаа 2 таславчийн цоорхой засах дурангийн мэс засал хийсэн. 2. 2025 оны 05 сарын 12-16-ны өдрүүдэд УНТЭ-ийн ЧХХСМЗТ-ийн эмч Н.Ган-Эрдэнэ Орхон аймгийн БОЭТ-д томилогдон ажиллаж, чихний хэнгэрэг нөхөх мэс засал 3, хамрын дурангийн мэс засал 6, гадна хамрын хуучин хугарал засах мэс засал 2, нийт 11 мэс засал хийж, ажлын байран дээр дадлагажуулах сургалт хийсэн. УНТЭ-ийн ЧХХСМЗТ-ийн эмч Н.Ган-Эрдэнэ Орхон аймгийн БОЭТ-д ажиллах хугацаандаа УНТЭ-т хийгддэг 3 таславчийн цоорхой засах мэс засал болон ахисан шатны хамрын дурангийн мэс заслыг орон нутагт анх удаа хийсэн  Зураг 12. Н.Ган-Эрдэнэ эмчийн Орхон аймагт хийсэн мэс заслын явцаас

4	Дурангийн чиглэлээр	1. 2024 оны 11 сараас 2025 оны 05 сар хүртэл хугацаанд УНТЭ-ийн Гастроэнтерологийн төвийн дурангийн эмч А.Алтангагнуур Өвөрхангай аймгийн БОЭТ-д 5 удаа алсын дуудлагаар ажиллан, нийт 10 удаа ERCP эмчилгээг хийж, ажлын байран дээр дадлагажуулах сургалт хийсэн. Зураг 13. Өвөрхангай аймагт 2. 2024 оны 05 сард УНТЭ-ийн Гастроэнтерологийн төвийн дурангийн эмч А.Алтангагнуур Орхон аймгийн БОЭТ-д алсын дуудлагаар ажиллан, 1 тохиолдолд ERCP эмчилгээг хийсэн. Зураг 14. А.Алтангагнуур эмч Орхон аймагт
---	---------------------	--

5	Дүрс оношилгооны чиглэлээр	2024 оны 12 сарын 15-аас 2025 оны 06 сарын 16-нд УНТЭ-ийн Дүрс оношилгооны төвийн 5 эмч Зайн оношилгооны төвд ажиллаж нийт 207 Компьютер томограф болон Рентген шинжилгээнд дүгнэлт бичиж, дүүрэг, орон нутгийн эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
6	Бусад	1. 2025 оны 04 сарын 25-ны өдөр УНТЭ нь Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газраас ирсэн хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон сумдын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан сургалт зохион байгуулсан. Сургалтын үеэр УНТЭ-ийн эмнэлзүйн үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, өвчтөний аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ, халдварын сэргийлэлт, хяналт, эмийн эмчилгээг зохицуулах хороо болон сувилахуйн албаны үйл ажиллагааны чиглэлээр танилцуулга хийж, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Мөн Өвөрхангай аймгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд УНТЭ-ийн эмнэлзүйн тусламж үйлчилгээ, эмзүй, сувилахуйн алба, ариутгал халдваргүйтгэлийн тасгийн үйл ажиллагаатай ажлын байран дээр нь танилцаж, туршлага судалсан. Зураг 15. Сургалтын явцаас 2. 2025 оны 02 сарын 13-аас 14-нд УНТЭ-ийн дотор, мэдрэлийн 8 эмчийн бүрэлдэхүүнтэй баг Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд “Жирэмсэн үеийн эрхтэн тогтолцооны эмгэгүүдийн хяналт менежмент” сэдвийн хүрээнд Өмнөговь аймгийн 16 сум болон БОЭТ-ийн 80 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. УНТЭ-ийн Дотор, мэдрэлийн эмчийн баг: ➤ Л.Анхбаяр /Зүрхний төвийн дарга/ “Жирэмсэн үеийн зүрх судасны эмгэг ба хяналт, менежмент”

- Б.Халиун /Бөөрний төвийн эмч/ “Жирэмслэлт ба бөөрний архаг өвчин”
- А.Нансалмаа /Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төвийн дарга/ “Жирэмсэн үеийн тромбоцитопени”
- Б.Ууганбаяр /Гастроэнтерологийн төвийн их эмч/ “Жирэмсэн үеийн элэгний өвчний менежмент”
- Д.Содгэрэл /Уушги, харшил судлалын төвийн их эмч/ “Уушгины хатгалгааны ялган оношилгоо”
- С.Янжмаа /ДШСДТ-ийн дарга/ “Жирэмслэлт ба таргалалт, Жирэмсэн үеийн ЧШ-ийн оношилгоо, эмчилгээ, хяналт”
- Э.Хөлгөн /ХҮСҮСТ-ийн их эмч/ “Аутоиммуны эмгэг ба жирэмслэлт”
- Б.Энхзориг /Мэдрэлийн эмнэлзүйн төвийн их эмч/ “Жирэмслэлт ба амилуулах тусламжийн дараах гэмтэл” сэдвээр тус тус лекц уншсан.



Зураг 16. Өмнөговь аймагт ажилласан УНТЭ-ийн баг бүрэлдэхүүн



Зураг 17. Өмнөговь аймагт зохион байгуулсан сургалтын явцаас

3. Хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд УНТЭ-ийн Ерөнхий мэс заслын тасагт хорт хавдрын дараах хими эмчилгээний 10 ортой нэгж байгуулан ажиллаж байна. Мөн УНТЭ-т хорт хавдрын олон талт тусламж, үйлчилгээг оновчтой үзүүлэх зорилгоор “Tumor board” буюу “Хорт хавдрын зөвлөлийн журам”-ыг боловсруулж, зохих шатны зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон.
4. Төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба, Сургалт эрдэм шинжилгээ хамтын ажиллагааны алба, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Зүрхний төв хамтарсан 4 хүний бүрэлдэхүүнтэй баг 2025 оны 05 сарын 23-аас 27-ны өдрүүдэд Увс аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлгийн 45 эмч, сувилагч нарт “Эрүүл ирээдүйг хамтдаа бүтээх эмнэлгийн менежмент” сэдэвт сургалт зохион байгуулсан.



Зураг 18. Сургалтын явцаас



Зураг 19. Увс аймагт хийсэн үзлэг

Түүнчлэн УНТЭ-ийн баг Увс аймгийн Нэгдсэн эмнэлэгт зүрх судасны эмгэгтэй 10 жирэмсэн эх болон 30 иргэн, элэгний хавдартай 10 хүнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн.

Хянасан

Ц.Амаржаргал

Ц.Амаржаргал, Захирлын ажлын албаны дарга

Боловсруулсан

Ц.Наранчимэг

Ц.Наранчимэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн